

Нэгдсэн хуралдааны
эцсийн хэлэлцүүлэгт
2025.01.22

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ГААЛИЙН ТАРИФ, ГААЛИЙН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 40 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 40.11 дэх хэсэг нэмсүгэй:

“40.11.Хархорум хотын хөгжлийн ерөнхий **төлөвлөгөө** болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд туссан техник, эдийн засгийн үндэслэл бүхий барилгажилтын төслийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулах барилгын материал, тоног төхөөрөмжийн нэмэгдсэн өртгийн албан татвар төлөх хугацааг 4 жил хүртэл хугацаагаар сунгах, эсхүл уг татварыг 4 жилийн хугацаанд хэсэгчлэн төлүүлэх шийдвэрийг Хархорум хотын зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар гаргаж болно.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хархорум хотын **төлөвлөлт**, бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс **эхлэн** дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Нэгдсэн хуралдааны
эцсийн хэлэлцүүлэгт
2025.01.22

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ХОТ, ТОСГОНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

~~1 дүгээр зүйл. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн “Нэг.Улсын зэрэглэлтэй хот” гэсэн хэсгийн 4 дэх заалтад дор дурдсан өөрчлөлт оруулсугай:~~

~~“1/ “Шинэ Хар хөрүм” хотын нэрийг “Хархөрүм” гэж;~~

~~2/Хотын Зөвлөл, Захирагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага “Өвөрхангай аймгийн Хархөрин сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал”, “Өвөрхангай аймгийн Хархөрин сумын Засаг дарга” гэснийг “Хархөрүм хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуульд зааснаар” гэж.”~~

1 дүгээр зүйл. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн “Нэг.Улсын зэрэглэлтэй хот” гэсэн хэсгийн 4 дэх заалтыг бүхэлд нь хассугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хархөрүм хотын **төлөвлөлт**, бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Нэгдсэн хуралдааны
эцсийн хэлэлцүүлэгт
2025.01.22

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар
хот

“Хархорум” хотын талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Хөт, төсгөны эрх зүйн байдлын тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг, Хөт байгуулалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалтыг **хэсгийг** үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын зэрэглэлтэй “Шинэ Хархорум” хотын нэрийг “Хархорум” хот гэж өөрчилсүгэй.

1.Хархорум хотын төлөвлөлт, бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хууль батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/“Хархорум” хотын төлөвлөлт, бүтээн байгуулалтын үйл ажиллагааг Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Хархорум хотын төлөвлөлт, бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хууль, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн зохион байгуулах;

2/“Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны төсөв, хөрөнгө, эрх, үүрэг, бүтэц бүрэлдэхүүнийг Хархорум хотын Захирагчийн ажлын албанд шилжүүлэх.

2."Хархорум" хотын бүтээн байгуулалтын үйл ажиллагааг Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хууль, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн зохион байгуулахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.

3.Хотын Зөвлөл, Захирагчийн сонгууль зохион байгуулагдах хүртэлх хугацаанд хотын Зөвлөл болон Захирагчийн чиг үүрэг, бүрэн эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдсон шилжилтийн үеийн зохицуулалтыг Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн 35 дугаар зүйлд заасныг үндэслэн зохион байгуулахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.

~~4.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Улсын Их Хурлын 2023 оны 01 дүгээр сарын 12 ны өдрийн 07 дугаар тогтоолын гарчгийг Орхоны хондийд “Хархорум” хот байгуулах тухай гэж, мөн тогтоолын 1, 2 дахь заалт, түүнчлэн 2 дахь заалтын 1, 2, 3 дахь хэсгийн “Шинэ Хархорум” гэснийг “Хархорум” гэж, Улсын Их Хурлын 2024 оны 06 сарын 05 ны өдрийн “Хот байгуулах тухай” 72 дугаар тогтоолын 1 дэх заалтад тусгасан хүснэгтийн “Нэг.Улсын зэрэглэлтэй хот” гэсний 4 т заасан “Шинэ Хархорум хот” гэснийг “Хархорум” хот гэж тус тус өөрчилсүгэй.~~

5.4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо /Ж.Бат-Эрдэнэ/, Эдийн засгийн байнгын хороо /Р.Сэддорж/-нд тус тус даалгасугай.

6.5.Энэ тогтоолыг Хархорум хотын **төлөвлөлт**, бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж ~~мөрдөнө~~ мөрдсүгэй.

Гарын үсэг